

**ХАНАХ ЗАСЛЫН БАГАЖИЙН ХЭРЭГЛЭЭГ  
СУРВАЛЖ БИЧИГТ ТУЛГУУРЛАН ТОДРУУЛАХ НЬ**

Д.Бямбажаргал<sup>1</sup>, Н.Ууганбаяр<sup>2</sup>, Б.Балжинням<sup>3</sup>, Б.Халиунаа<sup>4</sup>, Ш.Болд<sup>5</sup>

<sup>1,4</sup>“Ач” АУИС

<sup>2,3</sup>Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,

<sup>5</sup>Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

**DETERMINING THE USAGE OF BLOODLETTING TOOLS BASED ON  
ANCIENT MEDICAL BOOKS**

Byambajargal D<sup>1</sup>., Uuganbayar N<sup>2</sup>., Baljinnyam B<sup>3</sup>., Khaliunaa B<sup>4</sup>., Bold Sh<sup>5</sup>

<sup>1,4</sup>“Ach” Medical University

<sup>2,3</sup>Mongolian University of Pharmaceutical Sciences

<sup>5</sup>Traditional Medical Research Institute

**Abstract**

Bloodletting is a medical tradition that probably began in prehistoric times. Its rationale was based on the belief that removing blood eliminated “impure blood”. From antiquity until the beginning of the 20th century, bloodletting was considered a panacea, and it was the most common and versatile form of medical treatment. Not only was it believed to cure the sick, but also to promote vigor in the healthy. Some of the ancient books of traditional medicine noted that the bloodletting tools is very importance when opening a vessel in order to bleed. Traditional medical bloodletting tools are one of the oldest archeological findings, and researchers have found many types of bloodletting tools in our country dated back thousands of years. Therefore, research on bloodletting tools an important component of bloodletting therapy, is of theoretical and practical importance. The location, indications, and tools of bloodletting therapy and bloodletting vessels are described in detail in the “Subsequent Tantra” of “Four Medical Tantras”, and its commentaries: Dar mo sman rams pa blo bzang chos grags “Dka’ phreng mun sel sgron”, Sde srid sangs rgyas rgya mtsho “Be edurya sngon po” and Luvsanchoinpil “Gces btus snying nor” so on. The first Mongolian surgical work is directly related to the historical tradition of bloodletting therapy. It is now known that the stone needles, which was discovered in the 3000th millennium BCE, may have originated from the Mongolia used to use in medicine as bloodletting tools. In the seventeenth and nineteenth centuries, Mongolian medical bloodletting tools were passed down through India and Tibet medical books, and later the science of surgery and bloodletting therapy became more sophisticated and comprehensive knowledge. At the same time, it is clear that there is every reason to say that it has been enriched by the medical knowledge of the neighboring countries and improved by their own experience.

**Keyword:** Bloodletting, traditional medicine, tradition and tools

**Үндэслэл**

“Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиол, түүний тайлбаруудад ханах засалд тохирох өвчин нь “доргисон ба хямарсан хижиг, хавдар, яр, тулай, сүрьеэ, гал намс, шар ус, хулгана яр

тэргүүтэй халуун ба цус, шараас болсон өвчин бүгд” хэмээн дурдсан байдаг<sup>1,2,3</sup>. Ийм өргөн хүрээтэй хэрэглэдэг энэхүү эмчилгээний арга 1937 оноос 1990 он хүртэл маш явцуу хүрээнд хэрэглэгдэж, үр дүнг шууд ажиглалтаар үнэлэн гаргаж байсан бөгөөд харин 1990

оноос хойш хануур заслын үйлдлийн механизмыг тодруулах судалгаа тухайлбал хануур засал хийснээр имуносупрессив чанартай цусны улаан эс бий болж буй эмгэг жамын механизм нь прооксидант үйлдэлтэй төмрийн ионы хэмжээ мембранд ихэсч хэт исэлдэлт өдөөдөгтэй холбоотой хийгээд хануур заслын нөлөөгөөр цусны сийвэнгийн төмрийн хуримтлалыг багасгах тутам цусны улаан эсийн мембранд хэт исэлдэлтийн хорт бүтээгдэхүүн буурч, дархлал сэргээх идэвхтэй болж хувиран уламжлалт анагаах ухааны онолоор муу-цусыг биеэс ялгаруулж байгаатай төстэй саногенезийн үзэгдэл явагдаж байгаа тухай дүгнэлтэд хүрлээ<sup>5</sup> гэсэн судалгаанууд хийгдсэн байна.

Энэ мэт хануурын онолын судалгаа хийгдэж байгаа боловч ханах заслын гол тулгуур хануурын багажийн талаарх судалгаа хийгдэхгүй, хэрэглээ, нэршлийг оновчтой тогтоох асуудал тулгамдсаар байна.

**Судалгааны зорилго:** Хануур заслын багажийн нэр, хэрэглээ, хийх технологийг сурвалж бичигт тулгуурлан тодруулах.

**Судалгааны арга:** Аливаа нэгэн судалгааны ажлыг хийхэд хамгийн түрүүнд хэрэглэгддэг арга нь ном, зохиол, баримт бичиг судлах арга юм. Лекц тэмдэглэлийг баяжуулах, дэлгэрүүлэх, илтгэл, реферат болон дипломын ажил бичих, семинар ярилцлаганд бэлтгэх зэрэгт ном зохиол, хэвлэлийн эх материалтай ажиллах шаардлага зайлшгүй гардаг. Өөрийнхөө хэрэгцээ сонирхол буюу судлахаар сонгож авсан асуудалтай холбоотой бүхий л ном зохиолуудыг олж цуглуулах тэднийг ангилах, уншиж судлан ихээхэн хэмжээний мэдээлэл, мэдлэг баримт сэлттэй болох, тэмдэглэл хийх хэрэгтэй болдог. Бид судалгаандаа эрт цагийн маарамба, эмч, эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан хануур засалтай холбоотой судар ном зэрэг өргөн хүрээтэй мэдээллийн

эх сурвалжтай ажиллахдаа энэхүү аргыг ашиглав.

**Үрдүн:** Ханах засал, хануур хийх судасны байршил, заалт, багажийн талаар “АУДҮ”-ийн “Хойд үндэс”, түүний тайлбар зохиол Лодойжалбуугийн “Бэрх оньсны учир зангилааг тайлагч”, Дармо маарамба Лувсанчойдогийн “Харанхуйг арилгагч зул”, Лодойжалбуугийн “Дээдсийн сургаал”, Санжаажамцын “Хөх Биндэръяа”, Лувсанчойпилийн “Жидүйнинор”, Данзанпунцагийн “Дархадамба” зэрэг гол эх сурвалж зохиолуудад тодорхой бичжээ<sup>6,7</sup>.

1930 онд манай улсад ажиллаж байсан Оросын эмч М.Тубенский, С.Беленскийн нарын судалгааны бүтээлд уламжлалт анагаах ухааны үр дүнтэй олон аргууд одоо ч хэрэглэгдэж байгаагийн нэг нь хануур байна гэж дурджээ<sup>8</sup>.

Нэрт орчуулагч, төвөдөч И.Дэмбэрэлийн орчуулсан “Заслын дээд хануурын увдис, гэм хямралын булингарыг арилгах сарны гэрэл оршвой” сударт ханах засал хийх эмчийг тодорхойлохдоо “...бүхэнд мөншингүй мэргэнийг шүтсэн, асар ариун, мэдлэгтэй, сэтгэл төвшин, гартаа уян, ялгаж боддог, зоригтой, шинжээч, үйлэнд түргэн, эмийн үйлдэл нь сайн, багаж нь хурц, уур хилэнгүй, эх мэт асрал, энэрэл бүхэнд тэгш. Ийм эмч хануур хийснээр үйлэнд мэргэн” хэмээжээ<sup>9</sup>.

Профессор Б.Дагданбазарын “Монгол хануурын увдис” (1995) бүтээл нь ханах судасны байршлыг тогтоож, судасны олон улсын нэр, хануурын судасны байршлын бэрх оньс, өвчний заалт, эсрэг заалтыг орчин үеийн анагаах ухаантай холбож тайлбарласан нь уламжлалт анагаах ухааны эмч нарын гарын авлага болон хэрэглэгдэж байна<sup>10</sup>.

Ханах засал хийхэд хануурын багаж хэрэгсэл маш чухал болохыг уламжлалт анагаах ухааны тайлбар зохиолуудад бичиж тэмдэглэн үлдээсэн. Уламжлалт

анагаах ухааны хануурын багаж хэрэгсэл нь археологийн чухал олдворын нэг бөгөөд манай орны нутаг дэвсгэрээс олон зүйлийн хануурын багаж олдсоныг судлаачид тогтоосон байдаг. Монгол – Оросын хамтарсан Төв Азийн археологийн шинжилгээний анги 2001 онд Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутагт малталт хийж 7.6 см урттай, 3 мм зузаантай дөрвөлжин хэлбэртэй, 4 см орчим урт бөөрөнхийлөн зассан хүрэл шөвгийг олсон (Д.Эрдэнэбаатар, А.А.Ковалев 2004). Судлаачид эдгээр багажийг ханах, хатгах засалд хэрэглэж байсан хүрэл зэвсгийн үеийн багаж болохыг тогтоосон<sup>11</sup>.

Ютог Ёндонгомбын бүтээлд: Энэтхэгийн ёс нь ухааны билэг, билгийн ёс, Хятадын ёс нь ертөнцөөс хэтэрсэн, төрөх, үхэх, зурхайн ёс, Балбын ёс нь үхэх, төрөхийг засах үндэс, Качийн ёс нь үнэт эрдэнийг найруулах ёс, Монголын ёс нь өвчнийг гадагш нь татаж гаргах хануурын үндэс гэж номлосон. Бид дээр дурдсан эх судар, судалгааны бүтээлд тулгуурлан ханагч эмч, хануурын багажийг хэрхэн тодорхойлж бичсэнийг дараах байдлаар судлав. Үүнд: ханагч эмч, ханах багаж.

**Ханагч эмчийн шинж:** Ханагч эмчийн шинж тэмдэг нь ухаан саруул, мэргэдийг шүтсэн, асар ариун мэдлэгтэй, сэтгэл төвшин, гартаа уран, нүд хурц, ялгаж боддог, зоригтой, шинжлэх үйлэнд түргэн, эмийн эд болон багаж хэрэглэл нь хурц бөгөөд бүрэн, уур хилэнгүй, эх мэт асрал энэрэлтэй, бүх хүнд тэгш, энэхүү шаардлагыг хануурт тавьснаар үйлэнд мэргэн гэжээ (Зураг 1).



Figure 1. General condition of the physician who do bloodletting

**Ханах багаж:** Уг, хэлбэр, засал, хурцлах суурь, хадгалах сав дөрвөөс сайн гэдгийг нь мэдэх төмрийн зүйлийг хурц ир, хат төгөлдөр ширээж давтсаныг сайтар дархлан хэлбэр, засал чимэглэлийг тааруулан ер хийгээд ялгавартай үйлдэнэ (Зураг 2).




Figure 2. A set of bloodletting used by the Mongol maaramba

“АУДҮ” зохиолд үндэслэвэл заслын нийт багжийн тоо 82 байгаагаас гэлэн Ишдондовдамбийжалцан (Жамбалдорж)-гийн “Хиргүй болор эрхид номлосон эмээс ирсэн жишээ загвар үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршвой” сударт 61 багжийг нэг бүрчлэн тэмдэглэсэн байна (Зураг 3). Гэлэн Ишдондовдамбийжалцан (Жамбалдорж) нь Чингис хааны угсаа болох эцэг Балчиг хийгээд эх Балмо хоёрын хоёрдугаар хөвгүүн болж заяасан бөгөөд эцэг, эх нь түүнд Жамбалдорж гэдэг нэр хайрлажээ. Сахилын нэрийг нь Ишдондовдамбийжалцан гэдэг. Бид түүний бүтээлд тулгуурлан Монголд зонхилон хэрэглэж байсан хануурын багажийн хэрэглээ, хийх аргыг тодруулав.



Figure 3. Tools of bloodletting in the sutra “Mdzes mtshar mig rgyan” by Jambaldorj

Ерийн хэлбэр нь болжморын өд адил, үзүүр нь бөгтөр баралзад (мангайд) шинийн хоёрны сар адил буюу мөр нь зузаан шүд шулуун, өөхийтэй хутганы ир мэт бүрэлдэх болно. Барихад хялбар, уг бариул нь тогтоолготой байх ба таван эрдэнийн саванд муутуу буюу гуурсаар зөөллөн хадгална. Төмрийн өнгө нь удвал омботой (хөх удвал) адил бөгөөд үзүүр

нь дээшээ гал бадрах мэт, доод суурь нь бат, шил сэрвээнээсээ нарийсч тор хөвөрсөн мэт. Хануурын багажны хэлбэрийг 26 зүйлээр номлосон ч мангайд сүх, шилд (шилэн хүзүүнд) усан хутга адил, гүрээнд шинийн гуравны сар адил хөл, гарын хянганд болжморын өд адил, их судсанд илд адилыг хэрэглэнэ (Зураг 4,5,6,7,8,9,10,11).




Figure 4. Color drawing of the main bloodletting tools




Figure 5. A tweezer for picking out thorn in the vessel and tendon




Figure 6. In the eastern a feather like knife and in the western a knife with plain straight edge




Figure 7. Axe-shape knife




Figure 8. Lunar-day-shape knife with curved edge




Figure 9. Хулсан хутга мэт хануур




Figure 10. Round tip knife for cutting hair




Figure 11. Sickle-shape knife with swelling tongue

Жиншүг (булчингийн) судсанд хэлтгий сар мэтийг ашиглана. Бүхэлдээ урт, богины урт нь зургаан хурууны энтэй, чигчий хурууны хумсны хэмжээтэй, нэг ба гуравны хоёр

хийгээд гурван хувиудыг дээрх үе лугаа дараалал лугаа найруулна. Үзүүрийн хэлбэр нь хумсны үзүүрийн толио мэт шөрмөсөн дээр, шөрмөсний завсар, маханд үе дараалан

найруулна. Гэвч оронд аль тохирох хэлбэр ямх хэмжээ тэргүүтэн магадгүй дархны багажтай адил олон судсанд өөрийн санаачилгаар тохируулж зохицуулж болно. Шувууны өд буюу мөр нь зузаан хавтгай гол нь овгор тэргүүтэн, урлах хэмжээ нь арвайн шилбэний гол адил үзүүр нь нимгэн, шилбэ хүзүүгээрээ түүнээс 2 болох ,уг ёзоор нь 3 болох хүртэл дараалан зохицуулж үйлд ээ. Хурцыг гаргахад захаас нь ирийг үүсгэн, хичээнгүйлэн хажуу хавиас нь ирний хэлбэрийг гарган авч сандуг, гурван халуун, ар үр, манчин, нохойны үс, ямааны унгас, янгирын эврийн хяргасыг нунтаглан талхалж хануурыг усанд чийглэн дэвтээнэ. Ирний завсраас доош голд нь давтахгүйгээр шавар зуурч тумлайд (хумьж мухарлах), ирийг нь шавар нэвт халтал нүүрсний галд түлнэ. Цагаан болгохын хүсвэл архинд, хурц болгохыг хүсвэл усанд хий. Бор бөгөөд уян хатан болгохыг хүсвэл хүйтэн хар тосонд хийнэ. Зөөлрүүлж уяруулахад гүзээтэй тосонд хийх бөгөөд шалгаж үзэхэд хурцын хэмжээ нь гарын алганы махыг илж огтлох буюу үс тавьж үлээхэд хувааж чадахаар байна. Хануурын хуй (бүрээс) уртаараа есөн хурууны дотор хөндийд мөрийг бариулан үзүүр ишийг нэг хуруу хоосон хөндий байлгах бөгөөд өргөний хэмжээг зохицуулан цуугаар бооно. Бариул өндөгийг илээр орхино. Судал дарагчийн үзүүрийг хүргэлгүй гуурсны хөндийг тэлнэ. Хануурын ирийг мохоолгүй тавихад хялбар болно хэмээжээ. Дээрх судалгааны дүнгээс үзэхэд уламжлалт анагаах ухааны хануур заслыг шүн ёсоор хийхэд хануурын багажийн хэлбэр, хийх материал чухал болохын зэрэгцээ хийх арга, технологи, ирлэх ёс хүртэл ихээхэн ач холбогдолтой нь тогтоогдож байна.

**Дүгнэлт:** Монголчуудын мэс заслын анхны бүтээл нь хануурын түүхэн уламжлалтай шууд холбогдон АТӨ 3000 дахь мянганд олдсон чулуу зүүнээс эхтэй байж болох нь өнөөгийн хэрээр олдож буй баримтуудаар

тогтоогдов. XVII-XIX зуунд Монголын анагаах ухааны мэс заслын багаж хэрэгсэл Энэтхэг, Төвөдөөр дамжин уламжлагдаж хойшдоо мэс засал, заслын ухаан улам боловсронгуй болж цогц мэдлэг бий болсны зэрэгцээ түүнийгээ хөрш орны анагаах ухааны мэдлэгээр баяжуулан, өөрсдийн туршлагаар боловсронгуй болгосоор байжээ гэж хэлэх бүрэн үндэстэйг тодруулан гаргав.

### Ном зүй

- 1.Ханах засалд тохирох өвчин. Анагаах Ухааны Дөрвөн Үндэс. Хөх хот, 1997. Доод дэвтэр, х.504-506
- 2.Сүрэнжав.Ц, Ханах заслын бэлтгэл. Монгол Анагаах Ухааны хануур төөнүүрийн судлал. Хөх хот, 1990, х. 29-31
3. Рашааны цагаан шүүдэр. (хөрвүүлсэн Ш.Болд, Г.Дагва 1997). УБ, 1999.
4. Уул. Ханах заслын ул мөрийн сүвэгчлэл. ӨМ, МЭЭ, 1989, №2, х. 41-43
5. Цэрэндагва Д, Амбага М, Саранцэцэг Б, Төмөрбаатар Н. Хануур заслын үйлдлийн мембраны механизм. Монголын анагаах ухаан, 2001, 1(114)
6. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006
7. Цэрэндагва. Д. Тунгалаг, цөв боловсруулах үйл ажиллагааны алдагдал, муу цус, цус ялгах тан, ханах заслын харилцан шүтэлцээ. Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2018
8. Раднаабазар Ж, Должин-Очир Д. Хануур эмчилгээ. (Судалгааны өгүүлэл ) Монголын анагаах ухаан, 1986, 1(57)
9. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006
10. Дагданбазар Б. Монгол хануурын увдис, УБ, 1994. х.7- 26
11. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:  
АУ-ы доктор С.Базаррагчаа*